Тайлант онд 6,297 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 48,652 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.8 байна. Өнгөрсөн оны мөн үеэс эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 201 тохиолдлоор буурсан.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлого 3,164,200.0 мянган төгрөг буюу 24.2 хувиар өссөн дүнтэй байна. 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар гүйцэтгэлийн санхүүжилт 12,300,000.0 мянган төгрөгийн тусламж үйлчилгээг үзүүлэн ЭМДС-аас нэхэмжлэхээс 494,100.0 мянган төгрөгийн хасагдал хасч, 11 төгрөгийг олгохоор тооцоноос авсан санхүүжилт 11,184.8 мянган төгрөг ба 727,060.0 мянган төгрөгийн авлагатай гарсан. Гүйцэтгэсэн ажил үйлчилгээний 3.9 хувь нь хасагдсан ба өнгөрсөн оны мөн үед 3.7 % байснаас 0.2 %-иар хасагдал өссөн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын тухай хууль, Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 128 дугаар "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоол
- МУ-ын Сангийн сайдын 2024 оны А/52 тоот "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" тушаал
- ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоол
- ЭМДҮЗ-ийн 2023 оны 10 дугаар "Багц төлбөрийн хэмжээ, журам батлах" тогтоол

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээг хянаж баталгаажуулснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хянаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нэгдсэн эмнэлэг нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар журмаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 800,989.2 мянган төгрөгөөр буюу 5.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,683.9	139,970.0	134,286.1
Авлага	97,033.9	721,712.3	624,678.4
Бараа материал	1,376,708.5	1,539,310.5	162,602.0
Үндсэн хөрөнгө	12,680,678.2	12,554,753.2	-125,925.0
Нийт хөрөнгө	14,160,104.6	14,961,093.8	800,989.2
Өр төлбөр	846,965.2	0.00	-846,965.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	13,313,139.4	14,961,093.8	1,647,954.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	14,160,104.6	14,961,093.8	800,989.2

Дээрх хүснэгтээс харахад тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлаарх тайлангийн мөнгөн хөрөнгө нь 134,286.1 мянган төгрөг, авлага 624,678.4 мянган төгрөг, бараа материал 162,602.0 мянган төгрөг буюу 11.8 хувиар, эздийн өмч 1,647,954.4 мянган төгрөгөөр өсч, үндсэн хөрөнгө 125,925.0 төгрөг буюу 12 хувиар, өр төлбөр 846,965.2 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус эмнэлэг нь 2024 онд гүйцэтгэлээр санхүүжин Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулиудыг мөрдлөг болгон ажилласан.

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд стандартаар байх ёстой орон тооны доод хязгаарыг 314 эмч, эмнэлгийн ажилтнаар зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 11,336,274.7 мянган төгрөгөөр, өөрийн орлогыг 326,872.7 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 11,184,803.1 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 13,098,400.0 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр арга хэмжээ	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	биелэлт
1	71602-80101 үндсэн үйл ажиллагаа	11,462.8	11,008.9	453.9	96.0%
2	71602-80111 төрийн өмчийн барилгын тогтмол зардал	1,764.3	1,738.8	25.5	98.6%
3	71602-80802 ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	49.5	34.4	15.1	69.4%

4	71602-81639 төр төлбөрийг нь хариуцах эмийн зардал	42.2	42.2	-	100%
5	71602-83602 ЗД нөөц хөрөнгөнөөс хуваарилсан	15.1	15.1	-	100%
6	71602-83603 дээд шатны төсвөөс хуваарилсан	99.0	259	-160.0	261.6%
	Нийт дүн	13,432.9	13,098.4	334.5	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Майкрофт аудит" ХХК-ий аудитор Г.Майцэцэг, аудитор Б.Нарантуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер, дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол нар тус тус хэрэгжүүлсэн.

Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 22-ны өдрийн 01/21 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 14,551,751.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 21,827.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 309,246.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн 4 дүгээр зүйлд заасан хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2024 онд 13 мэдээллийг сар болон тухай бүр 156 удаа, 15 мэдээллийг тус бүр 1 удаа, бүгд 28 мэдээллийг 171 удаа бүрэн мэдээлсэн ба хуулиар хүлээсэн үүргийг 100 % хангаж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шатахууны тайлан, жолоочийн замын хуудсыг стандартын дагуу хөтлөх, спидометрийн заалтыг дахин нягталж шалгаж байх, шатахууны зарцуулалтын тооцоог нягталж байх зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй. Зөвлөмж.

Цалингийн шөнийн илүү цагийг бодохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-т заасны дагуу шөнийн цагийн нэмэгдэл хөлс /дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж /-ийг нэмж олгох заалтыг баримталж ажиллаагүй. Зөвлөмж.

Хувь хүнд ажлын хөлс олгохдоо 272.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар суутгаагүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 19.1.2 Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс шимтгэл суутгах заалтыг баримталж ажиллаагүй. Төлбөрийн акт тогтоох.

"Цалинг олгохдоо цалингийн цагийн бүртгэлийг үндэслэхгүй олгодог нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", хавсралтуудыг хэрэгжүүлээгүй. Зөвлөмж.

"ЭМДС-гаас даатгалын хасагдуулга 120,100.0 мянган төгрөг дутуу байхад албан хаагчдад хариуцлага тооцоогүй нь Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10-т "эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч

нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Зөвлөмж.

Эмийн тооллогыг түүврийн аргаар тулган баталгаажуулахад 4 нэр төрлийн 350 ширхэг нийт 203.9 мянган төгрөгийн эмийн дутуу тоологдсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нийт эмийн зардал зөрүүтэйг илтгэж байна. Төлбөрийн акт тогтоох.

Бараа материалын хүнсний тайлангийн дансны үлдэгдлийг агуулахтай тулган баталгаажуулахад 96.9 мянган төгрөгийн лапша гоймон дутсан байна. Энэ нь УСНБББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2 "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна. Төлбөрийн акт тогтоох.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, актыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	9,428.8	1	9,428.8	100%
Төлбөрийн акт	5	17,642.3	5	17,642.3	100%
Нийт дүн	6	27,071.1	6	27,071.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЭМД-сангаас эрүүл мэндийн байгууллагуудад эм, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөлсийг гүйцэтгэлээр санхүүжүүлэхдээ эх олонлогийн, сиситемийн, эмч байцаагчийн гэсэн 3 төрлөөр хассан тул дотоод хяналтыг сайжруулах

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын бус зардал гаргахгүй байх, жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллогыг заавал хийж хэрэгжүүлж үлдэгдлийг баталгаажуулж хэвших, бараа материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт бичиг хүчин төгөлдөр болно", "Анхан шатны бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэж тус тус заасан байдаг. Тиймээс компанийн эрх бүхий этгээдийн гарын үсэг тамга тэмдгээр баталгаажсан анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байх

Санхүүгийн тайлан болон Анхан шатны баримтыг үдэхдээ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, НББ тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу архивлан баримтжуулж, дотоод хяналтыг сайжруулахыг санхүүгийн албанд зөвлөж байна.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 573,194.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 573,194.0 мянган төгрөгийн төлбөрийн 3 акт тогтоож, 4 зөвлөмж өгсөн.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага бичигдээгүй байна.

5.3 Зөвлөмж

Шатахууны тайлан, жолоочийн замын хуудсыг стандартын дагуу хөтлөх, спидометрийн заалтыг дахин нягталж шалгаж байх, шатахууны зарцуулалтын тооцоог нягталж байх зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Зөвлөмж

Цалингийн шөнийн илүү цагийг бодохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-т заасны дагуу шөнийн цагийн нэмэгдэл хөлс /дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж /-ийг нэмж олгох заалтыг баримталж ажиллаагүй. Зөвлөмж

"Цалинг олгохдоо цалингийн цагийн бүртгэлийг үндэслэхгүй олгодог нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", хавсралтуудыг хэрэгжүүлээгүй. Зөвлөмж

ЭМДС-гаас даатгалын хасагдуулга 120,100.0 мянган төгрөг дутуу байхад албан хаагчдад хариуцлага тооцоогүй нь Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10-т "эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Зөвлөмж

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ**

2025 оны 02 дугаар сарын 21

Дугаар 01/42 - 25452520

Булган сум

ЗУА - 2025/114/ХА-СТА-7013

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс шимтгэл суутгах" заалтыг баримталж ажиллаагүй 272,300.0 (Хоёр зуун далан хоёр гурван зуун) төгрөгийг суутгаагүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.3-д "санхүүгийн тайлан болон үр дүнгийн гэрээнд уг үйл ажиллагааны талаар зохих ёсоор тусгасан байх", 44.1.5-д "туслах үйл ажиллагаа эрхлэх нь тухайн төсвийн байгууллагын чиг үүрэг, үндсэн үйл ажиллагаанд харшлахгүй байх" заалтуудыг хэрэгжүүлээгүй, эм, эмнэлэгийн хэрэгсэл худалдан борлуулах тусгай зөвшөөрөлгүйгээр иргэдэд худалдан борлуулж орлого олсон тул төлбөрийн акт тогтоох.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцволсноос үр дагавар үүссэн." гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Актаар тогтоосон 272,300.0 (Хоёр зуун далан хоёр гурван зуун) төгрөгийг Төрийн аудитын газрын төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нэгдсэн эмнэлэгийн даргын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Бүрэндондов), нягтлан бодогч (С.Ариунаа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ
"МАЙКРОФТ АУДИТ" ХХК-ИЙ
ЗАХИРАЛ, АУДИТОР  Г.МАЙЦЭЦЭГ

631714478
ГНД0048 3190209



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ**

2025 оны 02 дугаар сарын 21

Дугаар 99/48 - 25 452520

Булган сум

БУА - 2025 / 114 / КА - СТА - ТУЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Нэгдсэн эмнэлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эмийн тооллогыг түүврийн аргаар тулган баталгаажуулахад 4 нэр төрлийн 350 ширхэг нийт 203,994.0 (Хоёр зуун гурван мянга есөн зуун ерөн дөрвөн) төгрөгний эмийн дутуу тоологдсон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.3-д "санхүүгийн тайлан болон үр дүнгийн гэрээнд уг үйл ажиллагааны талаар зохих ёсоор тусгасан байх" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн." гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Актаар тогтоосон 203,994.0 (Хоёр зуун гурван мянга есөн зуун ерөн дөрвөн) төгрөгийг Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нэгдсэн эмнэлэгийн даргын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Бүрэндондов), нягтлан бодогч (С.Ариунаа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
"МАЙКРОФТ АУДИТ" ХХК-ИЙ
ЗАХИРАЛ, АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.МАЙЦЭЦЭГ





**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ**

2025 оны 02 дугаар сарын 21

Дугаар 03/49 - 25452520

Булган сум

ЗЧА-2025/174 НА-СГА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Нэгдсэн эмнэлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын хүнсний тайлангийн дансны үлдэгдлийг агуулахтай тулган баталгаажуулахад 96,900.0 (Ерөн зургаан мянга есөн зуун) төгрөгийн хүнс дутагдсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.3-д "санхүүгийн тайлан болон үр дүнгийн гэрээнд уг үйл ажиллагааны талаар зохих ёсоор тусгасан байх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн." гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Актаар тогтоосон 96,900.0 (Ерөн зургаан мянга есөн зуун) төгрөгийг Төрийн аудитын газрын төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нэгдсэн эмнэлгийн даргын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Бүрэндондов), нягтлан бодогч (С.Ариунаа) нарт хариуцуулав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
"МАЙКРОФТ АУДИТ" ХХК-ИЙ
ЗАХИРАЛ, АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ
Г.МАЙЦЭЦЭГ

